

ТӨРИЙН ТУСГАЙ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЭРХ, ХЭРЭГЖИЛТ

О.Эрхэмзаяа.

ДХИС-ийн Удирдлагын Академийн
8011 дүгээр дамжааны суралцагч,
хошууч

Хураангуй: Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 1-т “эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хамгаалах нь төрийн үүрэг мөн”, 38 дугаар зүйлийн 7-д “хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журам бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээг авч, хэрэгжүүлнэ”⁴⁵ гэж заасан.

Түүнчлэн “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 1 дүгээр зүйлд “Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын үндсийг тодорхойлоход оршино”, 4 дүгээр зүйлийн 4.1-т “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн”⁴⁶ гэж тус тус заажээ.

Дээрхи зүйл заалтууд нь цагдаагийн байгууллагаас иргэдийн амар тайван, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн үндэс юм. Цагдаагийн байгууллага, тэдгээрийн төрөлжсөн албаны зорилт нь өөр хоорондоо ялгаатай байх боловч, үндсэн зорилт нь гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлэх, нийтийн хэв журмыг хамгаалах ажлын үр нөлөөг ямагт дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийг цаг тухайд нь таслан зогсоох, учирч болох хор уршгийг нь аль болох гаргуулахгүй, нэмэгдүүлэхгүй байх, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг нэмэгдүүлэх, тухайн үйл ажиллагааны зохион байгуулалтыг боловсронгуй болгох, цагдаагийн албан хаагчийн гүйцэтгэх дадлагын чадвар, түвшинг цаг ямагт дээшлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг тууштай хамгаалах явдал юм.

ТТАХ нь төрийн албан хаагч байхаас гадна хүн болохын хувьд Үндсэн хуулиар баталгаажуулсан “Хүн бүр хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах... эрхтэй.” (16.4), Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан “Хүн бүр хөдөлмөрлөх, ажлаа чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн шударга аятай нөхцөлөөр хангуулах ...” (23.1)-ийн эрхтэй. Энэ эрхийн хэрэгжилтэд Засгийн

⁴⁵ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

⁴⁶ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

газраас онцгойлон анхаарч байгаа болохыг “Алсын хараа-2050”, Засаглалын талаар баримтлах бодлогын 5.4 дэх зорилтын хүрээнд 2050 он гэхэд “төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа бүрэн хангагдсан байна” хэмээн зааснаас харж болно. Гэвч хууль, эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хэрэгжилт хангалтгүй байна. Учир нь ТТАХ-ийн албан үүргийн онцлогоос шалтгаалан ажлын байраа хадгалах, нэр төр, аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор ТТАХ-ийн зүгээс хөдөлмөрлөх эрхийн зөрчлийг далд хэлбэрт байлгах тохиолдол түгээмэл байдаг. Цагдаагийн байгууллагын алба хаагчдын хөдөлмөрлөх эрх хангагдаж байгаа эсэхийг дараах хэд хэдэн шалтгаант байдлаас харж болох юм. Үүнд :

1.Хувцас хангалт. ТТАХ-ийн албан үүргээ гүйцэтгэж байх үедээ хэрэглэх дүрэмт хувцасны талаарх суурь харилцааг Төрийн албаны тухай хуулиар зохицуулдаг. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн албаны тухай хуулийн 63.1-д “Төрийн албан хаагч хуульд заасны дагуу дүрэмт хувцас хэрэглэж болно” хэмээн заасан. Улмаар ТТАХ-ийн хувьд Төрийн 8 албаны тухай хуулийн 63.2.-д зааснаар “Албан хаагчийн дүрэмт хувцасны загварыг эдэлгээний хугацаа, хэрэглэх журмын хамт Ерөнхийлөгч, Засгийн газар тус тус тогтоодог. Гэсэн хэдий ч, бодит байдал дээр ТТАХ-ийн дүрэмт хувцасны хүртээмж нь хангалтгүй байна. Засгийн газраас 2022 онд явуулсан судалгаанаас үзэхэд хоёр алба хаагч тутмын нэг нь дүрэмт хувцасны хангалт муу гэсэн үнэлгээ өгсөн байна.

2. Тусгай хэрэгсэл. ТТАХ-чдын хувьд тусгай чиг үүргийн ажил үүргийг гүйцэтгэх тул ажил үүргийн хүрээнд шаардлагатай тусгай хэрэгслээр хангагдсан байх асуудал нэн тэргүүнд тавигдана. Холбогдох хуульд заасан үндэслэл, журмын дагуу төрийн тусгай алба хаагч нь биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болдог . Гэсэн хэдий ч, анкет болон ярилцлагын судалгаанаас үзэхэд нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсгийн хангалт нийтлэг байдлаар туйлын хангалтгүй улаан гараараа гэмт хэрэгтэнтэй үзэж байгаа нь нийгмийн бодит үнэн.

3.Цалин. ТТАХ-ийн цалингийн суурь харилцааг Төрийн албаны тухай хуулиар зохицуулдаг. Төрийн албаны тухай хуулийн 57.2.3-т ТТАХ-ийн цалин нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн болон хуульд заасан бусад нэмэгдлээс бүрдэхээр байна. Өнөөгийн үнийн ханш, мөнгөний бодлоготой харьцуулан үзэхэд цалин нь амьжиргаандаа хүрэлцдэггүй. Төр засгаас удаа дараагийн бодлогын хэмжээнд цалин нэмэгдүүлэх арга хэмжээ авсан нь үнийн өсөлтөд өртсөөр л байна.

4. Ажлын ачаалал, илүү цагийн хөлс. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн зургаадугаар бүлгийн 84 дүгээр зүйлд долоо хоногийн ердийн ажлын цаг 40-өөс илүүгүй байна; ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цагаас илүүгүй байна гэж заажээ. Мөн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 116 дахь зөвлөмжид хэвийн ажлын долоо хоногийн үргэлжлэх хугацаа 48 цагаас хэтэрсэн тохиолдолд ажилчдын цалинг бууруулахгүйгээр нэн даруй энэ түвшинд хүргэх арга хэмжээ авах ёстой талаар заасан бөгөөд Монгол Улсын хувьд Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна гэжээ.

Цагдаагийн байгууллагын алба нь ажлын ачаалал их, илүү цагаар ажиллах шаардлага үүсэж болох ч алба хаагчид илүү цагаар ажилласан мөнгөө тооцуулан авч чаддаггүйгээс гадна ээлжийн амралтын хоногийг бүрэн гүйцэт эдэлж чаддаггүй байна.

5. Эрүүл мэндийн баталгаа. ТТХА нь хөдөлмөрийн аюулгүй нөхцөл байдалд ажиллах шаардлагатай байдал тул эрүүл мэндийн баталгааны асуудал нь суурь шинжтэйгээр яригдах учиртай. Гэсэн хэдий ч, судалгаанд хамрагдсан байгууллагуудын албан хаагчдын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хангалтгүй хэмээн дүгнэж болохоор байна. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж ажлын боломж муу,

Засгийн газраас явуулсан судалгаанаас харахад алба хаагчийг шагнах, урамшуулах тогтолцоо оновчтой, шударга байж чаддаггүй гэж 24,4% нь, алба хаагчдын мэдлэг, боловсролыг дээшлүүлэх талаар хангалттай дэмждэггүй гэж 20,2% нь, албан тушаал дээшлүүлэх үйл ажиллагаа хууль ёсны дагуу явагддаггүй гэж 21,7% нь, цол олгох, зэрэг дэв ахиулах гэх мэт үйл ажиллагаа зохих журмын дагуу явагддаггүй гэж 16,6% нь, алба хаагчид тогтвортой, удаан хугацаанд ажилладаггүй гэж 24,5% нь, байгууллагын хэмжээнд алба хаагчтай холбоотой гаргаж байгаа шийдвэр нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцдэггүй гэж 14,4% нь, алба хаагчтай холбоотой хууль бус шийдвэр гарсан тохиолдолд засах, хөндөгдсөн эрх, ашиг сонирхлыг сэргээх талаар арга хэмжээг авдаггүй гэж 19,4% нь үзжээ. Эдгээрээс алба хаагчид тогтвортой удаан хугацаанд ажилладаггүй, алба хаагчийг шагнах, урамшуулах тогтолцоо оновчтой биш гэсэн үзүүлэлтүүд хамгийн өндөр байна.

Алба хаагчид тогтвортой урт хугацаанд ажилладаггүй хамгийн том шалтгаан нь цалин, хангамжийн хүртээмжээс болдог байна. Зах зээлийн ханштай харьцуулахад ганцхан төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага төдийгүй төрийн алба нийтээрээ цалин бага гэдгийг бид хүлээн зөвшөөрнө. Цалин бага учраас чадварлаг боловсон хүчин цалин өндөртэй хувийн байгууллагад орох хүсэл эрмэлзэл их эсвэл гадаад явах сонирхол

маш их байгаа нь анзаарагдсан юм. Энэ байдал даамжирвал төрийн алба хүний нөөцгүйдэж, төрийн албаны залгамж чанар алдагдаж, улмаар үндэсний аюулгүй байдалд муугаар нөлөөлнө. Тиймээс төрийн албанд чадварлаг боловсон хүчнийг тогтвор суурьшилтай, урт удаан хугацаанд ажиллуулах хамгийн том нөхцөл нь түүний цалин, хангамжийг сайжруулах явдал юм.

Анхаарах асуудал :

1. Албан хаагчдын дүрэмт хувцасны нэр төрлийг журмаар тогтоож, төсөв багтаан тавихыг эрмэлздэг боловч, дүрэмт хувцасны нөөцийн хүрээнд асуудал үүсэж байна. Хэдийгээр, дүрэмт хувцасны хангалт тааруу тул нөөц үүсгэх боломжгүй байдаг боловч, гэнэтийн осол аваар, түймэр, үер усны аюул зэрэг байгалийн гамшигт үзэгдэл болсон үед нөөцгүй байдаг тул албан хаагчдын эрх зөрчигдөх нөхцөл байдал үүсдэг байна. Иймээс гэнэтийн үйл ажиллагаанд хамрагдах албан хаагчдын хувцасны нөөцийн асуудалд анхаарах хандуулах шаардлагатай.

2. ТТАХ-ийн эдийн засгийн баталгааг авч үзэхдээ зөвхөн цалингийн түвшингөөр бус өрхийн орлогод тулгуурлан харах, үүнийг нийгмийн баталгаатай нь уялдуулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байна. Ялангуяа, Онцгой байдлын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штабын албан хаагчдын нийгмийн баталгаанд онцгойлон анхаарал нь зохистой байна.

3. Эрүүл мэндийн баталгаа: Эрүүл мэндийн баталгаа нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг төдийхнөөр хязгаарлагдахын зэрэгцээ энэ нь чанар, хүртээмжийн хувьд хангалтгүй байна.

Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссоос 14 дэх илтгэлдээ Цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийн талаар доор дурдсан дөрвөн саналыг тусгаж, шийдвэр гаргуулахаар хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл хэрэгжсэнгүй.

1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 429 дүгээр тушаалаар “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс, дэд хэсгийн байранд тавигдах ерөнхий шаардлага” CS11-0244:2014 стандартыг хэрэгжүүлж, илүү цаг, амралтын болон бүх нийтийн баярын өдөр ажилласан алба хаагчдад хуульд заасан нэмэгдэл цалинг заавал олгож хэвших, шаардагдах төсвийг баталж өгөх;

2. Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолын дагуу цагдаагийн газар, хэлтсийг бүтэц, орон тоогоор нь ажиллуулах асуудлыг яаралтай

шийдвэрлэж, цагдаагийн алба хаагчдын хөдөлмөрлөх эрхийг хамгаалж, албаны үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг хангах;

3. Цагдаагийн алба хаагчийг жил бүр эрүүл мэндийн дэлгэрэнгүй үзлэг оношилгоонд оруулах зардлыг төсөвт тусган баталж, нэгдсэн журмаар зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

4. Хөдөлгөөний аюулгүй байдал хангах чиг үүрэг бүхий алба хаагч албан үүргээ гүйцэтгэж байгаад зам тээврийн осолд өртсөн тохиолдолд тухайн асуудлыг гэмт хэрэг, зөрчил эсэхээс үл хамааран үйлдвэрлэлийн осолд тооцож, хуульд заасан нөхөн төлбөр олгож байх.

5. Хөдөлмөрлөх эрх нь зөрчигдсөн алба хаагчийн асуудлыг нэхэмжлэн

хамгаалах эрх зүйн орчин бүрдээгүй байна. Үүнтэй холбогдуулан авч үзэхэд ажлын байрны дарамт, дарга цэргийн ялгаа арилаагүй байгаа нь хөдөлмөрлөх эрх зөрчигдөж залуу боловсон хүчнүүд нэнэ нөхцөл байдлаас болж, шантарч ажлаасаа ихээр гарч байгаа нь ажиллах орон тооны хямралд орж үүнээс улбаалан ажиллаж байгаа алба хаагчдын ажлын ачаалал ихсэж эрүүл мэнд, ар гэртээ тавих анхаарал суларч байна.

6. Манай улсад хөдөлмөрлөх эрхийн хүрээнд өөр нэгэн тулгамдаж буй асуудал бол үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөлд тодорхой хэмжээгээр өртөж байна.

Дүгнэлт

Монголын ард түмэн “Хэдэн бор цагдаа” гэж ярьдаг нь” анхааралдаа авах үг гэж энэ завшааныг ашиглан хэлэх байна. Сүүлийн үед “төрийн модон бамбай” ч гэж ярих болсон. Энэ үг бүрийн цаана Цагдаагийн алба хаагч хэнийг хамгаалаад байна вэ агуулга ч гэсэн цухалзаж байгаа. Энэ бүгд нь эцэст нь нэг л үгийг илэрхийлж байгаа байх. Тухайлбал. Цагдаагийн алба хаагчийн хөдөлмөрлөх эрх зөрчигдөж байгаа нь түмний нүдэнд ил болжээ гэсэн үг. Мөн Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шударга бус явдал байгааг ч гэсэн ард түмэн олж харсан л гэсэн үг. Дээрх судлагдсан байдлаас үндэслэн дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Цагдаагийн алба хаагчийн хувцасны хангалт хоорондын хугацаа хол, хуучирч муудсан хувцастай алба хаагчид албан үүргээ гүйцэтгэж байна. Энэ нь Цагдаагийн байгууллагын нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлж байна.

2. Эргүүлийн алба хаагчдаас бусад алба хаагчдад тээврийн зардал олгож дэмжлэг үзүүлэхгүй байгаа нь ар гэрийн ахуй амьдралын хүртээмжийн байдалд нөлөөлж байна.

3. Монгол Улсын Хөдөлмөрийн хуулиар нэг хүн өдөрт 8 цаг ажиллах ёстой гэж заасан Цагдаагийн алба хаагчид дунджаар 16 цаг ажиллаж байна. Үүнээс шалтгаалан ар гэрийнхэндээ зориулах цаг зав байхгүйн улмаас цагдаад ажилладаг залуу гэр бүлийн салалт ихэссэн байдаг.

Эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
2. Цагдаагийн албаны тухай хууль. 2017 он
3. Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль. 1993 он
4. “Алсын хараа -2050” Засгийн газрын уртхугацааны хөгжлийн хөтөлбөр
5. Хүний эрхийн байгууллагын 14 дэх удаагийн илтгэл
6. Төрийн тусгай алба хаагчдын эрх зүйн байдалд хийгдсэн судалгаанаас- 2022 он